



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 644

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09/05, 2023 оны 11/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, 4 нэрийн, нийт 71,906,200.00 (далан нэгэн сая есөн зуун зургаан мянга хоёр зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Д.Дэлгэрсайхан, Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Оюунгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006797
33-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
64 дугаар тогтоолын хавсралт

ОРХОН АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН
ХӨРӨНГИЙГ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ОРХОН
АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ЭЗЭМШҮҮЛЖ, БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Канон (canon LBP-6030 printer Lazer)	14	399,300.00	5,590,200.00
2	Скайнер (epson)	6	3,696,000.00	22,176,000.00
3	Киоск машин	1	24,640,000.00	24,640,000.00
4	Архивын нягтруулсан шүүгээ	16	1,218,750.00	19,500,000.00
	Нийт дүн			71,906,200.00 (далан нэгэн сая есөн зуун зургаан мянга хоёр зуун)